

туршилт явуулсан болон хэрэглэж эхэлсний үр дүнд англи хэл шинжлэх ухаан танин мэдэхүйн ухагдахууныг шууд тусгаж илэрхийлэх өндөр ач холбогдолтой болохоо харуулсаар байна. Шинжлэх ухааны ярианы хэлний хэл найруулга нь мэдлэг, мэдээллийг дамжуулахын өмнө сонсогч олон нийтийн боловсролын түвшинг урьдчилан судалж, төлөвлөсөн байхыг шаарддаг онцлогтой байна. Энэ удаад бид шинжлэх ухааны хэл найруулгын талаар өнгөц авч үзсэн болно.

Номзүй

Монгол хэл дээр

1. Баттогтох Д. (2007), Эрдэм шинжилгээний найруулга, УБ.
2. Отгонсүрэн Ц. (1998), Монгол хэлний найруулга зүй. УБ.
3. Сүхбаатар Ц. (2012), Монгол хэлний найруулга зүй. УБ.
4. Чадраа Б. (2000), Монголын Нэвтэрхий толь. УБ.
5. Паламдорж Ш. (2009), Судлахуйн үндэс. УБ.

Гадаад хэл дээр

1. Ashton, Rosemary (2016), “ Society for the Diffusion of Useful Knowledge. Oxford Dictionary of National Biography. Oxford University Press.
2. “About the university: Nineteenth and twentieth centuries”. (2016), University of Cambridge. Retrieved 31 Oct
3. Brossard, Dominique, Lewenstein, Bruce, Bonney, Rick (2005), Scientific knowledge and attitude change: The impact of a citizen science project. International Journal of Science Education.
4. Bucchi, M & Trench, B (2016), “Who pays for science” Barkeley University.
5. Carter Sigglow J. (1996), Correspondence, Nature.
6. Durant John, Evans G. A. & Thomas G.P. (1989), ”The Public Understanding of Science, Nature 340: 11-14
7. Swales J. (1990), Genre analysis: English in academic and research settings. CUP Cambridge.
8. Scheufele, D, A, (2006), Messages and heuristics: How audience form attitudes about emerging technologies. In Turney J. (Ed.), Engaging science: Thoughts, deeds, analysis and action, in Londonpage.

ОЛОН НИЙТИЙН ОРЧИН ДАХЬ НЬОД УРЛАГИЙН БҮТЭЭЛД ЦЕНЗУРТЭЙ ХАНДАХ НЬ

Д. Золбоо

МУИС, Утга зохиол судлалын багш, МА

Orcid:0009-0003-7514-6354

З. Намуун

МУИС, Урлаг судлал хөтөлбөрийн бакалавр

Abstract: *In this article, we aim to determine how nude artwork can be distinguished from pornography to determine the difference in its meaning and to answer whether it is necessary to censor nude artwork in public spaces. Although in any society, there should be an age limit on the public display of nudes (television, social media, such as mass media), classical works of art are not intended to be obscene but to illustrate the perfect person and to make the*

observer who feels the beauty of nature. Thus, censorship of nude art shouldn't be approached from the social side (e.g., obscenity); it should be approached from the beauty side.

Key word: television, social media, illustrate, beauty side.

Удиртгал

Ньюд гэх үг нь *nudus* гэх латин үгнээс гаралтай ба XVI зууны үед ньюд гэх англи үг бий болсон байна (Creswell, 2021). Ньюд нь цаашлаад ньюдизм буюу эрүүл мэнд, тав тухтай байдлын үүднээс хувцасгүй амьдрах амьдралын хэв маягийг хэлдэг. Дэлхийн нэгдүгээр дайны дараа ньюдизм Европ даяар тархаж, 1930-аад оны үед Хойд Америкт үүссэн. Америкийн биеийн соёлын холбоо нь 1929 онд ньюдизмийг сурталчлах зорилгоор байгуулагдсан байна.

Ньюд буюу нүцгэн биеийн дүрслэл (цаашид бид ньюд гэдэг үгийг ашиглах болно) нь урлагийн ертөнцөөс салгаж боломгүй нэг хэсэг яах аргагүй мөн билээ. Урлагийн түүхийн туршид уран бүтээлчид амьдарч буй нийгэм, соёлоос хамаараад янз бүрийн утга агуулга, зорилго зориулалттай бүтээсээр байна. Тухайлбал, Палеолитын үед хамаарах Виллендорфын “Венус нь үржил шим, газар тариалангийн бэлгэдэл, хүүхэд төрүүлэх эмэгтэйн амьдрал бэлэглэгч тэнгэр юм” (Kissick, 1995, х.43). Мөн сэргэн мандалтын үеийн Сандро Боттичеллигийн “Венус мэндэллээ” (1486) бүтээлд “Венусыг тэнгэрлэг гэгээн байдал, төгс гоо сайхны биет илэрхийлэл” (Жэйнс, нар, 2013, х.34) гэж үздэг. Харин модерн урлагийн ньюд бүтээлүүд үүнээс арай өөр утга агуулгатай дүрслэгддэг. Тухайлбал, Францын зураач Эдуард Мане “Олимпиа” (1863) зургаа зурахдаа зургийн гол дүрээ Венусыг зурдаг хэв маяг болох хажуу тийш налан хэвтсэн дүрслэлээр зурсан боловч тэрээр үүгээрээ Венус бурхныг үзүүлэхийг зориогүй билээ. Манегийн “Венус” бол үнэндээ шалдан эмэгтэйн дүрслэл юм. Дээр дурдсанчлан ньюд дүрслэлийг эрт дээр үеэс бэлгийн дур хүсэл өдөөхөөс өөр зорилгоор бүтээж ирсэн. “Олон нийтийн дунд зураг юм уу, үгээр бэлгийн амьдралыг илэн далангүй, ил тод өгүүлэх нь нийгмийн өөрийнх нь төрхийг зөрчиж, мэдээж ичгүүр сонжуургүй байдал гаргаж буй хэрэг мөн” (Вольф, 1960 [2021], х.366). Гэтэл ньюд зураг нь ичгүүр, сонжуургүй дүрслэл огтоос биш юм. Харин “бэлгийн харьцааг хүнлэг бус болгохыг онцгойлон зорьдог, хүн төрөлхтнийг эд зүйл, бараа бүтээгдэхүүн гэж үздэг зүйл бол порнограф юм” (Louw, 2017, х.55).

Бид 2022 оны наймдугаар сард Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн гэр хорооллын нутаг дэвсгэр дээрх худгийн гадаа ханан дээр уг худгийн газрын ажилтан Вильяма-Адольфа Бугрогийн “Сайкег хулгайлсан нь” (1895) нэртэй зураг зурж, олон нийтийн дунд маргаан үүсгэж, улмаар уг зургийг арилгасан үйл явдлаас үндэслэж, урлагийн бүтээл дэх ньюд дүрслэл гэж юу болохыг тайлбарлаж, уг бүтээл нь хэдийгээр сонгодог бүтээлүүдийн нэг ч гэлээ монголчууд бидний олон нийтийн орон зайд энэ төрлийн бүтээлийг дэлгэн тавихдаа цензуртэй хандах ёстой юу? гэх асуултад эш үндэс, судалгаатай хариулт өгөхийг зорив. Энэхүү асуултад хариулт өгснөөр нийгэмд бий болоод байсан эргэлзээг бага ч гэсэн тайлж, сонгодог ньюд урлагийн тухай мэдлэг өгөх ач холбогдолтой.

Цензур гэдгийг Уолтер Бернс, “нийгэм дээрх ичгүүргүй байдалд хориг тавихыг хэлнэ” (Вольф, 1960 [2021]) гэжээ. Цензур гэх үг нь үргэлж хууль, дүрэм журам гэх үгсийг дагуулж явдаг. “Урлагийн бүтээлийг цензурдэнэ гэдэг нь уран бүтээлчийн илэрхийлэх эрх чөлөөнд халдаж буйгийн

илрэл” (Вольф, 1960 [2021], х.369) болно. Платон урлаг бүтээгчдийг хуулбарлагч хэмээгээд, Гомер мэт урлаг бүтээгчид жинхэнэ мэдлэг бүтээдэггүй, жинхэнэ амьдралаас хол, хүний оюун мэдлэггүй зүйлийг бүтээдэг хэмээгээд урлагт цензур тавихыг оролдож байлаа (Plato, 1943). Түүний энэхүү цензур нь улс төр, удирдлагатай холбогдож байдаг нь тодорхой харагддаг. Гиймээс урлагийн бүтээлд цензуртэй хандаж буй нь урлагийн эстетик үнэлэмж бус нийгмийн цензур, хэвшмэл ойлголтын үүднээс шүүж байгаа хэрэг болно. Уран бүтээлчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүлээн зөвшөөрдөг ч энэхүү эрх чөлөө нь зөвхөн уран бүтээлийн орших эрхэд хамаарч байдаг. Хэрэв урлагийн бүтээл нь зураачийн урлангаас гарч нийтийн эзэмшилд орвол хувь хүний эрх чөлөө гэхээс илүү олон нийтийн үнэт зүйлс, үнэлэмжээр тодорхойлогдох ёстой болдог (Henley, 1997).

АНУ-ын Калифорнийн урлагийн клубийг 1913 онд үүсгэн байгуулсан зохиолч, сэтгүүлд Эверетт Кэррол Максвелл нь “Fine arts” сэтгүүлд хэвлүүлсэн “*The Value of the Nude in Art*” (1911) өгүүлэлдээ, “Дүрслэх урлагт тухайлбал гомдол, цөхрөл, баяр хөөр зэрэг сэтгэл хөдлөлийг илэрхийлэх боломжтой цорын ганц хэрэгсэл нь хүн. Хүнийг нүцгэн дүрсэлснээр уран сайхны хамгийн дээд хэлбэр болно” гэж үзсэн. Девид Хенли “*Art of Disturbance: Provocation and Censorship in Art Education*” (1997) бүтээлдээ цензур нь урлагийн багш нарын нийгмийн хариуцлагын тодорхой хүрээнд уран бүтээлийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгох үүрэгтэй холбоотой. Урлагийн багш нар урлагаар өдөөн хатгасан агуулга бүхий залуу уран бүтээлчдийг зөв боловсорсон ухамсартай бүтээл хийх хэрэгтэй гэж үзжээ. “*Strategies for Dealing with Censorship*” (1996) хэмээх бичвэртээ Лорри Блэйр багш нар урлагийн талаар мэдлэгтэй байж, урлаг соёлын талаар хүүхдэд ойлгуулж ярихдаа, цензуртэй хандах хэрэгтэй. Харин уран бүтээлчид цензурт орох тусмаа уран бүтээлээ туурвисаар байх хэрэгтэй” гэж уриалсан. Мэри Деверо “*Protected Space: Politics, Censorship, and the Arts*” (1993) өгүүлэлдээ уран бүтээлчийн бие даасан байдал болон урлаг дахь улс төрийн оролцоог багасгах, хүүхдийн хүмүүжилд урлаг хэрхэн нөлөөлдгийг авч үзсэн.

Ньюд урлагийн бүтээлийн талаар олон нийтийн сэтгэгдэл, тэдний үзэл бодлыг асуулгын аргаар авахдаа цахим хэлбэрийг ашиглав. Ньюд урлагийн бүтээлүүдтэй холбоотой мэдээллүүдийг нэгтгэн судлав. Баруунд олон нийтийн орон зайд тавьсан урлагийн ньюд бүтээлд цензуртай хандаж байсан мэдээ баримтыг шүүн нэгтгэн судлав.

Судалгааны хэсэг

Нүцгэн хүний дүрслэл дүрслэх урлагийн түүхэнд гол чухал сэдвүүдийн нэг билээ. Сэргэн мандалтын үеийн алдартай зураачид хүний биеийн булчин шөрмөс, хөдөлгөөн зэргийг зурахын тулд анатомийн судалгаа хийдэг байсан нь сэргэн мандалтын үеийн зураач Леонардо да Винчигийн бүтээлүүд дээрээс тодорхой харагддаг. Ингэснээр тэд гайхамшигтай төгс ньюд бүтээлүүд хийж байв. Учир нь хэчнээн мянган удаа хүнийг зурахдаа гутал хувцсыг нь зурлаа ч гэсэн хүний биеийн анатомитой холбож өгөхгүй л бол тэр урлагийн бүтээл амьгүй, сүнсгүй мэт хиймэл болох юм. “Баруунд дүрслэх урлаг үүссэнээс хойш зураач, уран барималчид хүнийг нүцгэнээр дүрсэлсээр өнөөг хүрсэн. Урлагийн түүхээс харахад тэд ихэвчлэн эмэгтэй хүнийг нүцгэн дүрсэлж байв. Хүний биеийн анатомийн бүтцийг төгс ойлгох нь урлагийн бүх мэдлэгийн үндэс юм” (Maxwell, 1911, х.10).

Барууны урлагийн сор болсон ньюд бүтээлүүдийн ихэнх нь музей, галерей зэрэг газруудад хадгалагдан олон нийтэд урлагийн бүтээлийг олж харах боломж олгож байна. Сонгодог ньюд урлагийн бүтээлүүдийг зарим улс орон олон нийтийн орон зайд ямар ч маргаангүй байршуулсан байдаг бол зарим улс оронд энэ нь улсын хэмжээний том хэлэлцүүлэг өрнүүлсэн жишээ байдаг. Жишээ нь, Флоренц дахь Синориагийн талбайд Микеланжелогийн Давидийн баримал одоог хүртэл буй атал Эрл Каммингсын сонгодог гоо зүйн шинжийг агуулсан бүтээл нээлтээ хийснээс хойш хэдхэн долоо хоногийн дараа сонин хэвлэлд орон зайг олж, бүдүүлэг хэлэлцүүлэг өрнөхөд хүргэсэн байна. Түүний ньюд баримлыг “Калифорнийн их сургуулийн захирагчид барималч руу хаалган дээрх нүцгэн биеийн дүрслэлийг болиулж хувцастай болгох, эсвэл оронд нь бүрэн хувцастай шинэ баримал бүтээхийг шаардсан” (Maxwell, 1911, х.9) гэж мэдэгджээ. Үүнээс гадна “1989 онд Роберт Маппльтропийн авсан ижил хүйстэй эрчүүдийн авсан гэрэл зураг АНУ-ын Үндэсний боловсролын холбоо (NEA)-нд маргаан үүсэхэд нөлөөлсөн байна. Үүний учир шалтгааныг тайлбарлахдаа ёс суртахуунгүй урлагийн бүтээлүүд нь нийгмийн боловсролын хэрэгсэл болохгүй гэж үзжээ” (Devereaux, 1993, х.208). 1912 онд францын зураач Пол Чабас “September Morn” гэх зураг зуржээ. Өсвөр насны залуу охин жиндүү өглөө нуурын гүехэн хэсэгт нүцгэн зогсоно. Гэрэл зургийн *Jackson and Semmelmeier* нэртэй дэлгүүрийн цонхон дээр тавьсан байхад нь “Чикаго хотын захирагч болон цагдаагийн байгууллага хэдийгээр түүний уран бүтээлийг дэмжсэн ч зургийг дэлгүүрийн лангуу мэтийн хүүхдийн харагдах орчинд байж болохгүй гэж үзсэн” (Pattison, 1913, х. 244). Үүнээс гадна “1989 Лонг Айланд их сургуулийн С. В. Пост оюутны байрны дарга Девид Стайнберг их сургуулийн цуглуулган дахь эмэгтэй болон хоёр эрэгтэй ньюдийн усанд орж буй дүрслэлтэй “Сүлжээс” нэртэй зураач Петер Дрейкийн бүтээлийг оюутнуудын сурах орчинд байж болохгүй гэж үзэн нүүлгэхийг шаарджээ” (Atkins, 1991, х.37). Эдгээр тохиолдлоос үзэхэд зарим урлагийн бүтээл, тэрд дундаа ньюд бүтээлийг олон нийтийн орон зайд дэлгэн тавихдаа цензуртэй хандаж байсан нь харагдаж байна.

Олон нийтийн орчин гэж юу болохыг дараах байдлаар тайлбарлажээ:

Олон нийтийн орон зай (мөн олон нийтийн хүрээ) нь үүнийг хэн эзэмшиж байгаагаас үл хамааран хүн бүр зарчмын хувьд ашиглах боломжтой орон зайг хэлнэ. Олон нийтийн хүрээ нь орчны бүх хэсгүүдтэй холбоотой олон нийт чөлөөтэй нэвтрэх боломжтой орчин юм. Үүнд, нийтийн эзэмшлийн бүх гудамж, талбай, болон бусад зам, голчлон орон сууц, зарим байгууламж, худалдааны нээлттэй талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэг багтдаг (Planning and Housing Committee, 2011, х.47)

Тэгвэл олон нийтийн орчинд урлагийн бүтээл дэлгэн үзүүлэхэд олон нийтийн үзэл санаанд нийцсэн байх хэрэгтэй юу? “Урлагийн бүтээлд цензур тавина гэдэг нь олон нийтийн үнэт зүйлс, улс төр, бизнесийн үзэл бодол гэх мэт гоо зүйн бус асуудлууд дээр үндэслэн бүтээлээс татгалзах шийдвэрийг хэлдэг” (Henley, 1997, х.39). Олон нийтийн орчинд ньюд урлагийн бүтээл, тэр дундаа сонгодог хэлбэрийн ньюд урлагийг үзүүлэх тохиромжтой юу? “Нийгэмд тодорхой төрлийн урлагийн бүтээлийг зохимжгүй, эх оронч бус, арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан, гажуу буруу хандлагатай, садар самуун сурталчилсан гэх мэт шалтгаанаар хязгаарлах буюу хориглох тохиолдол байдаг” (Devereaux, 1993, х.209). Нийгэмд буруутгагдаж байдаг урлаг нь зөвхөн ёс суртахууны хувьд

төдийгүй гоо зүйн хувьд алдаатай байдаг уу? Урлагийг нийгмийн байдалтай хэт холбон нийгмийн ач холбогдлыг нь нэмэгдүүлэх тутам урлаг өөрийн бие даасан тусгаар байдлаа алдах эрсдэл үүснэ.

Зураг 1. Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг дэх (Монелийн худгийн ханан дээрх зураг)

Вильяма-Адольфа Бугрогийн эртний ромын домгийн сэдэвтэй “Сайкег хулгайлсан нь” (1895) (Зураг1) зургийг бүрэн зурж дуусаагүй байтал хэдэн хоногийн дараа уг бүтээлийг дан өнгөөр давхарлан будаж арилгажээ. Уг зураг нь Венус Сайкегийн гоо сайханд атаархаж, хүү болох Купиддээ Сайкег олиггүй эрд дурлуулахыг даалгадаг боловч унтаж байгаа Сайкегийн гоо сайханд Купид өөрийн эрхгүй татагдаж, түүнд дурлаж түүнийг хулгайлж буйг дүрсэлжээ. Эртний грек ромоос эхтэй нь урлаг гэж нэрлэгдээд буй цэвэр ариун шинжийг өөртөө агуулсан урлагийн бүтээлүүдийг шүүх нь зөв үү? Эдгээр урлагийн бүтээлүүд нь нийтийн эзэмшлийн газар тавигдах нь хэр зохимжтой байх вэ? гэдэг асуултын хариулыг авахаар бид тухайн урлагийн бүтээлийн илэрхийлэх гэсэн санаа, үйл явдал, үзэгчдэд энэ нь ямар сэтгэгдэл төрүүлж байгаа талаар нээлттэй болон хаалттай байдлаар асуумж бэлтгэн нийтдээ 114 хүнээс цахим хэлбэрээр судалгаа авсан. Энэхүү судалгаанд санхүү, эдийн засгийн салбарын 19.2%, боловсролын чиглэлийн 10.5%, инженерчлэлийн 9.6%, бизнес менежментийн 5.2%, болон бусад салбарын оролцогчид оролцсон (Зураг 3).



Зураг 2, 3. Судалгаанд оролцогчдод харуулсан зураг. Вильяма-Адольфа Бугро. Сайкег хулгайлсан нь. 1895

Вильяма-Адольфа Бугрогийн эртний грек, ромын домог зүйн шинжтэй “Сайкег хулгайлсан нь” (Зураг2,3) зургийн илэрхийлэх гэсэн санааг 22% нь мэдэхгүй гэж хариулсан бол хайр сэтгэлийн

утгатай гэсэн нь хамгийн олон буюу 24% байв. Ганцхан хүн буюу 0.9% зургийн нэрийг оновчтой хэлж, илэрхийлэх гэсэн санааг тодорхой тайлбарласан (График 1).




График 1. Та зургийн илэрхийлэх





График 2. Оролцогчдын ажил гэсэн санааг мэдэх үү? мэргэжлийн чиглэл

Харин тэдэнд ямар сэтгэгдэл төрж байгааг асуухад 57.1% сайхан, эерэг таатай мэдрэмж төрүүлж байна гэсэн бол таагүй мэдрэмж төрж байна гэсэн нь 3.5% буюу маш бага байсан. Ямар нэгэн сэтгэгдэл төрөөгүй буюу мэдэхгүй гэж харилсан нь 6.25% байна. Судалгаанаас харахад ньюд урлагийн бүтээл үзэгчдийн дийлэнхэд нь эерэг таатай мэдрэмжийг өгч байна гэж дүгнэж байна (График 3).

Танд ямар сэтгэгдэл төрж байна вэ?



■ Сайхан, таатай, эерэг сэтгэл хөдлөл
■ Урлагийн үр чадрыг гайхширсан
■ Таагүй
■ Мэдэхгүй болон нэг хариу үйлдэл үзүүлээгүй


График 3. Танд ямар сэтгэгдэл төрж байна вэ?

Зураач Бугрогийн Сайкегийн хоёр хувилбар зургийг насанд хүрээгүй хүүхдэд үзүүлж болохгүй гэж 39.5% нь үзсэн. Шалтгаан нь биеийн дийлэнх хэсэг ил гарсан, нүцгэн биеийн дүрслэлтэй бүтээлүүдийг бага насны хүүхэд хараахан ойлгож чадахгүй, иймэрхүү урлагийн бүтээлүүдэд насны хязгаар байх хэрэгтэй. Гэртээ хүүхдийнхээ хажууд нүцгэн явдаггүйтэй адил тодорхой хэмжээнд хувцасласан байх хэрэгтэй ба насанд хүрээгүй хүүхдүүдийн бэлгийн чиг хандлагад сөргөөр нөлөөлнө. Үүнээс гадна нийгмээсээ хамаараад, ялангуяа монголд эдгээр зургуудыг харуулах нь эрсдэлтэй, тэдний зарим нь зургийн ач холбогдлыг мэдэхгүй учир бага насны хүүхдэд харуулах хэрэггүй гэж үзжээ. Гэтэл 60.5% нь урлагийн бүтээлийг хүүхдэд үзүүлэхийг зөвшөөрсөн байна. Үүний учрыг тайлбарлахдаа эдгээр зургуудад ямар нэг гаж зүйл байхгүй, харин ч хүүхдүүд эдгээр зургийг харснаараа өөрийн эд эрхтний талаар ойлголттой болох ба Эртний грек, ромын домгийг унших нь хүүхдийн хүмүүжилд чухал үүрэг үзүүлнэ. Хүүхдийн хүмүүжилд ямар ч урлагийн бүтээл мэдлэг болж хүмүүжилд нь нөлөөлж, гоо зүйн туршлагыг нь нэмэгдүүлж байдаг. Гоо зүйн боловсрол эрт авах тусам хүний харах өнцөг хорвоог мэдрэх чадамж нь хөгжин өөрчлөгддөг. Хамгийн энгийнээр хүүхэд эрэгтэй эмэгтэй хүний ялгаатай байдал болон хүнийг хайрлаж, энэрэх тухай ойлголтыг дээрх зургуудаас авах бүрэн боломжтой гэж үзжээ (График 4).

График 4. Эдгээр зургийг насанд хүрээгүй хүүхдэд үзүүлж болох уу?

“Порнограф гэдэг нь порно, график гэсэн хоёр грек үгнээс гаралтай. Порнай нь перэйми гэх үгнээс үүсэлтэй, энэ нь 'худалдах' гэсэн утгатай бөгөөд ихэвчлэн хөлсний боол эсвэл биеэ үнэлэгчтэй холбоотой. График гэдэг нь бичигдсэн, бичээстэй, зурсан зүйлийг хэлдэг. “Порнограф” бол шууд утгаараа биеэ үнэлэгчдийг дүрслэх гэсэн утгатай” (Louw, 2017, х.55). Харин порнограф нь ньюдизмтэй адил нүцгэн биеийн дүрслэлийг харуулаад байгаа мэт боловч ньюд бүтээлүүдээс тэс өөр зорилготой. Дүрслэлийн хувьд ихэвчлэн нүцгэн биеийг маш ойроос харуулж, биеийн хэлэмж нь

Та эдгээр бүтээлүүдийг насанд хүрээгүй хүүхэд үзэж болно гэж бодож байна уу?



үзэгчийг өөртөө урин дуудсан, тэдний сонирхлыг бэлгийн хандлагаар татсан байдаг нь ньюд урлагийн бүтээлд биш харин порнографд насны хязгаар байх хэрэгтэйг харуулж байгаа юм.

Зураач Бугрогийн ньюд бүтээлийг хэтэрхий задгай, арьс гарсан, насны хязгаар тавих хэрэгтэй гэх мэт шалтгаанаар хүүхдэд үзүүлж болохгүй гэж байгаа боловч бидний зүгээс энэ асуудлыг тайлбарлахад ньюд бүтээлийг порнографын нэг төрөл гэж харж байгаа нь хүүхдэд үзүүлж болохгүй гэсэн дүгнэлтэнд хүргэсэн байж болох юм. Порнографын ньюдизмээс ялгагдах зүйл нь мэдээж илэрхийлэх гэсэн санаа болон тус бүр дүрслэгдсэн ньюд

дүрслэлийн биеийн төрх байдал болон дохио зангаа зэргээр ялгах боломжтой. Кино шүүмжлэгч Бенсе Наней порнограф болон ньюд гэрэл зургийн ялгааг, “үзэгч бүтээлийн зохиомжинд бус харин объектэд анхаарал хандуулж байвал порнограф, харин объект бус зохиомжид анхаарч байвал урлаг” (2013) хэмээн ялгасан.

1947 оны 3-р сард АНУ-ын шуудангийн алба Чикаго, Нью-Йорк, Филадельфи болон Охиогийн зарим хотуудад АНУ-ын ньюдист сэтгүүл болох *Sunshine and health* сэтгүүлийг тараахгүй

байхаар шийдвэрлэн энэ үйл явдал нь эцэстээ улсын шүүхэд очсон юм. Тус сэтгүүлд ньюдистүүдын хөдөлгөөнтэй холбоотой сурвалжилга, төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцож буй ньюдист эрэгтэй, эмэгтэй, хүүхдүүдийн гэрэл зургуудыг нэгтгэсэн байв. Шүүхэд очсоны үр дүнд “судлаачид болон шинжээчид дээрх сэтгүүл нь үнэхээр үзэгчдийг өдөөн хатгасан, бэлгийн хүсэл тачаалд автуулдаг эсэхийг судлахад S&H-ийн асуудал нь "байгалийн шинж чанартай бөгөөд ямар ч утга учиргүй", "шунал тачаал, бузар санааны шинж гэмдэг байхгүй", "ньюдистүүдийн итгэл үнэмшлийг тодорхой бөгөөд эрүүл байдлаар" танилцуулсан гэх зэрэг хариуг орлоцогчид өгсөн байна” (Hoffman, 2015, х.175).

Судалгаанд оролцогчдын 34.8% нь урлагийн бүтээлийг музей болон галерейд байх хэрэгтэй

гэж үзсэн бол хаа сайгүй гэж дүгнэсэн нь 24.1%, урлагийн бүтээлийг ойлгодог, урлагийн мэдрэмжтэй хүмүүсийн дунд үнэлэгдэх ёстой гэсэн нь 7.1%, тухайн урлагийн бүтээлийн төрлөөсөө хамаарч янз бүр байна гэсэн нь 1.7% байна. Харин урлагийн бүтээлийн хаана байх нь зөв, талаар мэдэхгүй байна гэж хариулсан нь 3.5% байна (График 5). Үүнээс харахад урлагийн бүтээлийг олон нийтийн зай талбайд байршуулах тухай бид төдийлөн хэлэлцдэггүй, тунгаадаггүй болох нь харагдаж байна.

Таны бодлоор урлагийн бүтээл хаана байх ёстой вэ?




График 5. Таны бодлоор урлагийн бүтээл хаана байх

ёстой вэ?

Дүгнэлт

Ньюд урлагийн бүтээлийн зорилго нь илүү өргөн хүрээг хамарч байхад порнограф нь ньюд бүтээлээс зорилго, агуулга дүрслэлийн хүрээнд ч явцуу байна. Харин цензур тавих нь ёс бус, гажуу буруу зүйлийг нийгмийн үнэт зүйлээс ангид байлгах боломжийг бий болгох бөгөөд бид сонгодог урлагийн бүтээлийг порнографтаас ялгаж байж цензуртэй хандах хэрэгцээ үүсэх юм.

Судалгааны үр дүнгээр оролцогчдын дийлэнх нь Бугрогийн бүтээлийг урлагийн бүтээл гэдэг талаас нь харж, ямар нэг цензур тавих шаардлагагүй гэж үзсэн бол цөөнх нь тухайн ньюд урлагийн бүтээлийг буруу зүйлийг хөхиүлэн дэмжсэн, биеийн арьс ил гарсан гэх шалтгаанаар цензуртэй хандах хэрэгтэй гэж үзсэн. Ньюд урлагийн бүтээл эрт дээр үеэс янз бүрийн нөхцлийн улмаас үүссэн бол порнографын зорилго хэзээд үзэгчийг өдөөн хатгасан, бэлгийн дур хүслийг ёс бусаар хангахыг

дэмждэг. Харин ньюд урлагийн бүтээлийг харснаараа хүн гоо зүйн таашаал, урлагийн бүтээлийг ойлгох боломжтой болдог.

Урлагийн бүтээлийг олон нийтийн орон зайд байршуулахдаа цензуртэй хандаж, түүнийг нийтийн эзэмшлийн газарт байрлуулахыг хориглох тохиолдлууд зөвхөн монголд бус дэлхийн улс орнуудад одоо ч гарсаар байна. Ньюд урлагийн бүтээлийг олон нийтийн орчинд дэлгэн харуулах нь ямар нэг байдлаар гажуу буруу зүйлд уруу татсан зүйл биш учир үүнд цензур тавих нь учир дутагдалтай юм. Тийм ч учир ньюд урлагийн бүтээлийг харагдах байдлаар дүгнэх биш түүний илэрхийлэх гэсэн санаа, зорилгыг нь илрүүлэх нь ньюд урлагийн бүтээл болоод порнографын хүрээ хязгаарыг тодруулан ялган салгах боломжтой болно

Ном зүй

Монгол хэл дээрх ном:

Вольф, Роберт Пол. (1960 [2021]). *Философийн тухай*. Улаанбаатар, Монгол: Мөнхийн үсэг Жэйнс, К., нар. (2013). *АУГАА уран зургууд*. Улаанбаатар, Монгол: Непко

Англи хэл дээрх ном:

Cresswell, J. (2021). *Oxford Dictionary of Word Origins (Oxford Quick Reference)*. Oxford University Press

Hoffman, B. (2015). *Naked: A Cultural History of American Nudism*. NYU Press.

Kissick, J. (1995). *Art context and criticism*. Synergy, Singapore: McGraw-Hill

Plato. (1943). *Plato's The Republic*. New York :Books, Inc.

Англи хэл дээрх сэтгүүл:

Atkins, R. (1991). A Censorship Time Line. *Art Journal*, 50(3), 33–37.

Blair, L. (1996). Strategies for Dealing with Censorship. *Art Education*, 49(5), 57–61.

Devereaux, M. (1993). Protected Space: Politics, Censorship, and the Arts. *The Journal of Aesthetics and Art Criticism*, 51(2), 207–215.

Louw, D. J. (2017). Aesthetics of the Naked Human Body: From Pornography (Sexualised Lust Object) to Iconography (Aesthetics of Human Nobility and Wisdom) in an Anthropology of Physical Beauty. InTech.

Maxwell, E. C. (1911). The Value of the Nude in Art. *Fine Arts Journal*, 24(1), 2–11.

Nanay, Bence, '9 Anti-Pornography: André Kertész's Distortions', in Hans Maes, and Jerrold Levinson (eds), *Art and Pornography: Philosophical Essays* (Oxford, 2012; online edn, Oxford Academic, 24 Jan. 2013)

Henley, D. (1997). Art of Disturbation: Provocation and Censorship in Art Education. *Art Education*, 50(4), 39–45.

РЭНДАЛЛ КОЛЛИНЗИЙН ЖУУХИЗМЫН СОЦИОЛОГИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

Су-мин Ху, Голуэйн Үндэстний Их Сургууль, Ирланд Улс.

Орчуулсан: А.Хишигтөгс, социологич, Ирланд Улс.

Abstract: This article reflects on Collins' classic work, *The Credential Society* (Collins, 1979), situating his critique of educational credentialism within broader 'conflict sociology' (Collins, 1975). The discussion reappraises Collins' work in the context of the 'new credentialism' and the race, gender and class concerns raised in current debates on higher education. The article characterizes contemporary higher education as being trapped in a Procrustean dynamic: techno-utopianism with job displacement and expansionism with declining public support. Collins attempts to escape the legacy of structural-functionalism through conflict sociology or predictions of systemic crisis. This is contrasted with his contemporary, Herbert Gintis' eclectic attempt to construct a transdisciplinary social science. The